

ЭРДЭНЭ РЕСУРС БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛЛОХ ЗӨВШӨӨРЛИЙГ АВЧ, БЭЛТГЭЛ АЖЛУУДЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2021.12.07

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Монгол Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамнаас (“БОАЖЯ”) Баян Хөндий алтны төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (“БОНБНҮ”)-ний зөвшөөрлийг авсныг мэдээлэхэд таатай байна. БОНБНҮ-г батлуулснаар Компани нь Баян Хөндий алтны төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлнэ.

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бид Баян Хөндий төслийн БОНБНҮ-г батлуулан, төсөл хөгжүүлэлтийн нэгэн чухал үе шатыг давсандаа баяртай байна. БОНБНҮ-д дурдсанчлан Баян Хөндий алтны төслийн зорилт нь байгалийн баялгийг хариуцлагатайгаар хөгжүүлж, оролцогч талуудад өгөөжийг бий болгох юм. Биднийг дэмжин ажилласан орон нутгийн оролцогч талууд, Монгол Улсын Засгийн газар, зөвлөх байгууллагууд болон Эрдэнэ Ресурсийн хамт олонд талархал илэрхийлье.”

“Ковид цар тахлын нөхцөл байдал, өвлийн улирал эхэлж байгаа зэрэг хүчин зүйлсийг харгалзан барилгын бүтээн байгуулалтыг эхлүүлэх шийдвэрийг хянуур гаргах шаардлагатай. Одоогоор бид 2022 онд бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Түүнээс гадна, Хар Морь, Улаан тусгай талбайд нээн илрүүлсэн өндөр агуулга бүхий нээлтүүд нь Баян Хөндий алтны төслийг үүсгэгч гидротермаль системийн цар хүрээг тэллээ. Баян Хөндий алтны төсөл нь олон сая унц бүхий алтны дүүргийн эхлэл болно гэдэгт бид итгэлтэй байна.”

Эрдэнэ Ресурсийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын судалгаа болон хариуцлага

Монгол Улсын хууль, журмын дагуу БОНБНҮ нь төслийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл болон эрсдэлийг тодорхойлох, Монгол Улсын байгаль орчны стандартад нийцүүлэн нөлөөллийг бууруулах стратегийг боловсруулах үндсэн тогтолцоо юм. БОНБНҮ-г Монгол Улс болон олон улсын стандарт, шаардлагын дагуу Эко Трейд ХХК боловсруулсан. БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөс 2021 оны 10-р сард Баян Хөндий алтны төслийн БОНБНҮ-г батлах шийдвэр гаргасан бөгөөд 2021 оны 11-р сарын эцэст баталгаажуулсан бичиг баримтыг хүлээн авсан. БОНБНҮ-ний зөвшөөрлийг хүлээн авснаар Эрдэнэ Ресурс нь барилгын тусгай зөвшөөрлүүдийн

өргөдлийг гаргасан бөгөөд 2022 оны эхэнд бүтээн байгуулалтын шийдвэр гарахаас өмнө бэлтгэл ажлуудыг эцэслэхээр ажиллаж байна.

2021 оны 7-р сард Компани нь Баян Хөндий алтны төсөл орших Баянхонгор аймгийн засаг даргын тамгын газартай Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ (“ОНХАГ”)-хийсэн. ОНХАГ-ний нөхцөлүүд нь тусгай зөвшөөрөл, бүтээн байгуулалт, олборлолт зэрэг чухал үе шатуудад суурилсан орон нутгийн иргэдийн ажлын байр, сургалт, орон нутгийн худалдан авалтуудтай холбоотой хөрөнгө оруулалтыг багтаасан.

Дээрх БОНБНУ-нээс гадна Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ (“ESIA”) -г Компанийн стратегийн хөрөнгө оруулагч Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк-аас тавигддаг Гүйцэтгэлийн Шаардлагын дагуу боловсруулсан. ESIA нь орон нутгийн иргэдтэй хийсэн хэлэлцүүлгийн хүрээнд нөлөөллийн хамрах хүрээ, нөлөөллийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулах болон хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ зэрэг дөрвөн үе шат бүхий цогц төлөвлөгөөг тодорхойлсон. Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийг салбарын тэргүүлэх туршлагын дагуу хөгжүүлж ашиглахад чиглэн, ESIA-ийн удирдлагын төлөвлөгөөнд нөлөөллөөс зайлсхийх, бууруулах төлөвлөгөөг багтаасан.

ESIA тайлан болон техникийн бус тайлантай компанийн вебсайтаас танилцах боломжтой.

ESIA тайлан (ENG): [https://bit.ly/Khhundii Gold Project ESIA](https://bit.ly/Khhundii_Gold_Project_ESIA)

Техникийн бус хураангуй (ENG): [https://bit.ly/Khundii Gold Project ESIA Non-Technical Summary](https://bit.ly/Khundii_Gold_Project_ESIA_Non-Technical_Summary)

ESIA тайлан (MNG): [https://bit.ly/Khundii Gold Project ESIA mon](https://bit.ly/Khundii_Gold_Project_ESIA_mon)

Техникийн бус хураангуй (MNG): [https://bit.ly/Khundii Gold Project ESIA Non-Technical Summary Mon](https://bit.ly/Khundii_Gold_Project_ESIA_Non-Technical_Summary_Mon)

Ирээдүйн төлөвлөгөө

БОНБНУ-ний зөвшөөрлийг хүлээн авснаар Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны төслийн талбайд агуулах, суурин кэмп, захиргааны барилга болон бусад үйлдвэрийн бус дэд бүтцийн барилгын зөвшөөрлийн өргөдөл гаргасан. Нарийвчилсан зураг төслийг эцэслэснээр боловсруулах үйлдвэрийн барилгын зөвшөөрлийн өргөдлийг 2022 оны 1-р улиралд гаргана.

Үүнтэй зэрэгцэн Компани нь худалдан авалтын ажлуудыг ахиулан, урт хугацааны бэлтгэл шаардах бутлуур, баяжуулах дамжлагын тоног төхөөрөмжийн захиалга өгсөн. Бэлтгэл ажлууд болох төслийн хяналтын гүйцэтгэл, их хэмжээний гэрээг хэлэлцэх болон сургалтын ажлуудыг төлөвлөсөн бөгөөд 2022 оны эхээр бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ. Компани Ковид-19 цар тахлын үед шаардлагатай бараа бүтээгдэхүүн, хүртээмжид нөлөөлөх нөлөөллийг хянан, ирэх саруудад төсөл хөгжүүлэлтийн хуваарь төсвийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл хүргэнэ.

Түүнээс гадна, Баян Хөндий алтны төслийн зэргэлдээ орших Улаан болон Хар Морь талбайд хайгуулын хөтөлбөр үргэлжилсээр байгаа. Одоогоор Баян Хөндий ордын баруун залгаа орших Улаан нээлтийн өргөтгөлийн өрөмдлөгийг эцэслэхээр ажиллаж байна. Үргэлжлүүлэн, Баян Хөндий Хар Морь талбайн хооронд 2.4 км структурыг шалгах гүехэн өрөмдлөгийн хөтөлбөр болон бүсийг хойд зүгт тэлэх хайгуулын хөтөлбөрийг гүйцэтгэнэ. Хар Морь талбайд дундаж гүнтэй (200-300 метр) цооногууд сонгон өрөмдөхөөр төлөвлөсөн. Гүйцэтгэж буй өрөмдлөгийн хөтөлбөр нь 12-р сарын эцэс хүртэл үргэлжлэх ба үр дүнгүүдийг 2022 оны 1-р улиралд танилцуулна. Эдгээр шинэ нээлтүүд болон тусгай зөвшөөрлийн талбай дахь хэтийн төлөв бүхий талбайнууд нь Баян Хөндий алтны төслийн хөгжүүлэлтэд эдийн засгийн чухал ач холбогдолтой.

Хөндий Алтны Дүүргийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг. Компани нь түүнээс гадна Хөндий Алтны Дүүргийн зүүн зүгт 30 км-т өөрийн 100% эзэмшлийн Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд томоохон Зуун Мод молибден-зэсийн орд болон хэд хэдэн зэс ба молибденийн порфирийн хэтийн төлөв бүхий бүсүүдийг хөгжүүлж байна.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор

¹ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

² Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2023 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурсийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>